



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/64

Ховд

┌ Үнэлгээний хороо байгуулах тухай ┐

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Ховд аймгийн Жаргалант сумын Рашаант багийн төвийн инженерийн шугам сүлжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга: Ш.Нохойжав - Орон нутгийн өмчийн газрын дарга

Гишүүд: Д.Ариунбилэг - Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын дарга

Б.Дэлгэрмаа - Төрийн бус байгууллагын төлөөлөл

Ц.Баяржаргал - Хувийн хэвшлийн төлөөлөл

Нарийн бичгийн дарга:

Ж.Батлхагва - Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Ш.Нохойжав/-нд даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Ж.Батлхагва/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД